



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2013 оны 07 сарын 17 өдөр

Дугаар 252

Улаанбаатар хот

Хорооны 2008 оны 66 дугаар тогтоолоор
батлагдсан журамд нэмэлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13.1.3, 14.2.5 дахь заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 66 дугаар тогтоолоор батлагдсан “Урт хугацааны даатгалын хураамжийн хэмжээг тооцох журам”-ын 3 дугаар зүйлд дор дурьсан агуулгатай 7, 8, 9, 10, 11 дэх заалтыг тус тус нэмсүгэй:

1/ 3 дугаар зүйлийн 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.11 дэх заалтууд:

“3.7. Даатгагч даатгалын бүтээгдэхүүн тус бүрийн нөөц сан тооцох актуар тооцооллын аргачлал, томъёоллыг Хороонд ирүүлсэн байна.

3.8. Даатгагч насжилтын хүснэгтийг өөрчлөх тохиолдолд өөрчлөх болсон шаардлага, тооцоололтыг боловсруулан эрх бүхий актуарчаар баталгаажуулж Хороонд ирүүлнэ.

3.9. Хорооны актуарч даатгагчаас ирүүлсэн насжилтын хүснэгтийг өөрчлөх болсон шаардлага, ирүүлсэн тооцоолол нь үндэслэлтэй гэж үзвэл дүгнэлтээ үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай тайлбараа даатгагчид албан бичгээр хүргүүлнэ.

3.10. Даатгагч нь Хорооноос үндэслэлтэй гэж үзсэн буюу шинэчлэгдсэн насжилтын хүснэгтийг ашиглан хураамжийн болон нөөц сангийн тооцооллыг хийнэ.”

3.11. Шинэчлэгдсэн насжилтын хүснэгт нь зөвхөн шинээр байгуулах гэрээний хувьд үйлчилж эхлэх бөгөөд өмнө нь байгуулсан даатгалын гэрээний хураамжид өөрчлөлт орохгүй болно.”

2. Журамд нэмэлт оруулж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Х.Бум-Эрдэнэ/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

000574